

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
МБСДС	Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
МСҮТ	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв

Агуулга

1.Аудитын гэрчилгээ.....	3
2.Аудитын тайлан	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3.Менежментийн захидал	10
4.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	14
а. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	14
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	14
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	0
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	0
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	1



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Г.ӨНӨРБАЯР ТАНАА

2020.03.25 № 06/346
танай _____-ны № _____-т
Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2020\0325SAG23.Docx

001051034

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



[Handwritten signature]

Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудитын тайлан

2.1. Оршил

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Өнөрбаяр Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн үндсэн хөрөнгийн хадгалалт хамгаалалтад анхаарах, биет бус хөрөнгийг зөв бүртгэх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 3 дугаар сарын 20-ноос 2020 оны 3 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор Л.Мөнхцацрал хариуцаж хэрэгжүүлэв.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 3/671 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь ерөнхий боловсролын сургуулийг төгсөгчид болон ажилгүй залуучууд, иргэдэд богино хугацаанд нийгэм, хөдөлмөрийн зах зээлд эрэлт хэрэгцээтэй байгаа мэргэжил эзэмшүүлж, ажлын байртай холбох замаар ажилгүйдэл, ядууралтай тэмцэх төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд оршино.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар үйл ажиллагааны чиглэл зорилтоо дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг дараахь байдлаар хуваарилан зарцуулна гэж заажээ. Үүнд:

- төрийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын тогтмол зардал, түүнчлэн сурагчийн дотуур байрны нийт зардал
- өмчийн хэлбэр харгалзахгүйгээр мэргэжлийн өөрийн өртгийг үндэслэн тогтоосон нэг сурагчид ногдох хувьсах зардлаар олгосон санхүүжилт, тэтгэлэг
- мэргэжил олгох, давтан сургалт зохион байгуулах зардал
- хувиараа аж ахуй эрхлэгч иргэнийг аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх арга барил, үр чадвар эзэмшүүлэх сургалтад хамруулах зардал

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн Acolous программ хангамж ашигладаг байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 7 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 3 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд олгосон хувьсах зардал, тэтгэмжийн зардал гол үйл ажиллагааны үзүүлэлт тул зардлыг суурь үзүүлэлтээр сонгосон.

Төлөвлөлтийн үе шатанд суурь үзүүлэлт 13,133,600.0 мянган төгрөгөөс тооцон 131,336.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тогтоолоо.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 286,036.4 мянган төгрөгөөр тогтоосон нь 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн суурь үзүүлэлтээс тооцсонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 840.5 мянган төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт орсон нь богино хугацаат өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага		840.5	840.5
Нийт хөрөнгө		840.5	840.5
Өр төлбөр		2,799,200.0	2,799,200.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/		(2,798,359.6)	(2,798,359.6)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн		840.5	840.5

Авлага дансны үлдэгдэл 840.5 мянган төгрөгөөр өссөн нь тайланд оны хувьсах зардлын санхүүжилтийн тооцооноос үүссэн авлага байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 2,799,200.0 мянган төгрөгөөр өссөн нь 2019 оны 12 дугаар сарын суралцагчдын тэтгэмж, хувьсах зардлыг олгоогүйгээс үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүн 2,798,359.6 мянган төгрөгөөр сөрөг үзүүлэлттэй гарсантай холбоотой байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, Засгийн газрын тусгай сангийн удирдлага нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд МСҮТ-ын суралцагчдын хувьсах зардлыг санхүүжүүлэхэд улсын төсвөөс 8,020,334.2 мянган төгрөг олгохоор, суралцагчдын тэтгэлгийг санхүүжүүлэхэд

Хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих сангаас 41,004,000.0 мянган төгрөг тус тус бүрдүүлэхээр баталсан байна.

Улсын төсвөөс 5,725,470.5 мянган төгрөг олгож, 2,294,838.7 мянган төгрөг дутуу олгосон нь суралцагчдын тооны бууралтаас шалтгаалж, дутуу санхүүжигдсэн байна.

Туслах үйл ажиллагааны орлого 41,004,000.0 мянган төгрөгөөр төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 18,588,300.0 мянган төгрөг бүрдсэн нь суралцагчдын тоо 45.3 хувьтай буюу төлөвлөсөн тооноос 3452-р бага хамрагдсантай холбоотой байна.

Тайлант онд Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт зориулан 49,024,334.2 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 24,313,795.5 мянган төгрөг зарцуулж, төсвийн зардлын гүйцэтгэл 49.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

Улсын төсвөөс олгосон 7,216,951.6 мянган төгрөгийн санхүүжилтээс дутуу зарцуулсан 1,491,456.1 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Мэргэжлийн түр сургалтын 3142, МСҮТ-ийн хэв шинжийг агуулаагүй сургалтын төвийн 4418, нийт 7560 суралцагчдад тэтгэлэг олгоогүйгээс 9,072,000.0 мянган төгрөг, суралцагчдын ирц 75 хувиас доош тохиолдолд тэтгэлэг олгоогүй, 2018-2019 оны хичээлийн жилд МСҮТ-д элсэгчдийн тоо төлөвлөснөөс буурсан зэрэг шалтгаанаар 24,710,538.7 мянган төгрөгийн хувьсах болон тэтгэлгийн зардал дутуу зарцуулагдсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 10 эрсдэл тодорхойлж, горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 27,342.6 мянган төгрөгийн 5 алдаа, зөрчил илэрснийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас тэтгэлэг авч буй Мэргэжлийн болон боловсролын сургалтын байгууллагад суралцаж буй суралцагсдын тоо, мэдээлэл технологийн төвийн цахим системээр хянагдсан мэдээллийн дагуу байгаа эсэх нь анхаарал татахуйц байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын шилэн дансны вебсайтад холбогдох мэдээллийг бүрэн оруулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 зөвлөмжийн хэрэгжилт 90 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Залруулагдаагүй 27,342.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 286,036.4 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй дүгнэлт өгч байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Зардлын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Тэтгэлэг олгосон төлбөрийн баримтад харилцагч байгууллагын нэхэмжлэхийг хавсаргаагүй, цахим системд оруулсан /МСҮТ-ийн оруулсан/ суралцагчдын нэрсийн дагуу, хувийн дансанд нь шууд шилжүүлэн олгож байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3-т "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог", 13.3-т "Аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 14.2-т зааснаас бусад өөрийн онцлогт тохирсон дотооддоо мөрдөх анхан шатны баримт, маягтыг дүрэмдээ заасан эрх бүхий удирдах байгууллагаар батлуулан мөрдөж болно", 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6. Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Сангийн сайдын 2018 оны 100 дугаар тушаалаар баталсан Аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн маягтыг хөтлөх аргачлал-д "Анхан шатны хүчин төгөлдөр баримт бүхий ажил гүйлгээг журналд бичнэ" гэж тус тус заасанд нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Суралцагчдын тооны зөрүү гарах, тэтгэлэг илүү /дутуу/ олгогдох

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтыг хуульд нийцүүлэн баталж, хөтлөх;
Хүчин төгөлдөр баримтын бүрдэл дээр үндэслэж нягтлан бодох бүртгэлийг хөтлөх

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлийг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

3.2 Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Тайлант онд 34170 суралцагчдад 41,004,000.0 мянган төгрөгийн тэтгэлэг олгохоор төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 15,490 гаран суралцагчдад 18,588,300.0 мянган төгрөгийн тэтгэлэг олгож, төсвийн гүйцэтгэл 45.3 хувиар биелэгдсэн, төлөвлөлт үндэслэлгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.2.2-д "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх" гэж заасанд нийцэхгүй байна.

3.2.2. Эрсдэл:

Төсвийн зарчим алдагдах, гүйцэтгэл хэрэгжихгүй байх

3.2.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийг үндэслэлтэй төлөвлөж, гүйцэтгэх

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлийг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

3.3 Хувьсах зардлын норматив

3.3.1. Илрүүлэлт:

Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативийг Засгийн газрын 2012 оны 94 дүгээр тогтоолоор баталснаас хойш 8 дахь жилдээ мөрдөн ажиллаж байгаа нь Боловсролын тухай хуулийн 40.3-т "Сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн, аймгийн төвөөс бусад сум, тосгон, багийн сургуульд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүрийг Засгийн газар жил бүр шинэчлэн тогтооно" гэж заасанд нийцэхгүй байна.

3.3.2. Эрсдэл:

Олгож буй хувьсах зардал ханшийн өөрчлөлтийн улмаас хүрэлцэхгүй болох

3.3.3. Өгсөн зөвлөмж:

Хувьсах зардлын нормативийг хуульд нийцүүлэн тооцож, Засгийн газраар батлуулах

3.3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлийг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

3.4 Зардлын данстай холбоотой асуудал

3.4.1. Илрүүлэлт:

Сургалтын төвд олгохоор тооцсон 5 дугаар сарын хувьсах зардлын санхүүжилтийг 27,342.6 мянган төгрөгөөр нэмж олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасантай нийцэхгүй байна.

3.4.2. Эрсдэл:

Дотоод хяналт сулрах, хоорондын тооцооны зөрүү үүсэх, өр, авлага үүсэх

3.4.3. Өгсөн зөвлөмж:

Санхүүжилтийг өөрчилсөн тохиолдолд түүнийг тооцсон, баталгаажуулсан, шийдвэр гаргасан албан тушаалтнаар баталгаажуулж, хүчин төгөлдөр анхан шатны маягтаар ажил гүйлгээг бүртгэх, тайлагнах

3.4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлийг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

3.5 Дотоод хяналт

3.5.1. Илрүүлэлт:

Тайлант онд яамны Дотоод хяналт, шалгалт үнэлгээний газраас 13-н сургалтын төвд суралцаж буй 4489 суралцагчдын тоонд шалгалт хийхэд 1403 хасагдаж, 3086 суралцагчаар баталгаажуулсан нь нийт 84-н МСҮТ-д суралцаж буй хүүхдийн тоо цахим бүртгэлийн тооноос дутуу байх, санхүүжилт илүү олгогдох эрсдэлтэй, шалгалтыг өргөжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

3.5.2. Эрсдэл:

Ашиглан үүсэх, үргүй зардал бий болох

3.5.3. Өгсөн зөвлөмж:

Дотоод хяналтын цар хүрээг өргөжүүлэх, хяналтыг нэмэгдүүлж, эрсдэлийг бууруулж ажиллах

3.5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлийг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

3.6 Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

3.6.1. Илрүүлэлт:

Мэргэжлийн сургалтын төвүүдийн суралцагчдад олгосон тэтгэлгийн санхүүжилтийг цаасан хэлбэрээр баталгаажуулж аваагүй нь Мэргэжлийн боловсрол, байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох журмын 3.2-т "Сургалтын байгууллага нь суралцагчийн тухайн сарын үнэлгээ, ирцийн мэдээллийг энэ журмын хавсралтад заасан маягтын дагуу мэргэжлийн боловсрол, сургалтын нэгдсэн цахим системд бүртгэх буюу дараа сарын 5-ны өдрийн дотор Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санд цаасан хэлбэрээр баталгаажуулан хүргүүлнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 20.2-д "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Сангийн сайдын 2017 оны 347 дүгээр тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 3-д "Харилцагч талуудын хооронд гарсан ажил гүйлгээг тодруулан тайлант үеийн эцэс дэх хоорондын тооцооны үлдэгдлийг баталгаажуулахдаа улирал, жилийн эцэст харилцагч талууд тооцооны үлдэгдлийн баталгааг үйлдэнэ. Шаардлагатай бол санхүүгийн тайлангийн дундуур хийж болно. Тооцооны үлдэгдлийн баталгааг тооцоо үүссэн данс тус бүрээр хөтлөнө", 2-д "байгууллагын тооцооны баримтыг тооцооны үлдэгдлийн баталгааны хавсралтад нэгтгэж гаргана" гэж тус тус заасанд нийцэхгүй байна.

3.6.2. Эрсдэл:

Ашиглан үүсэх, үргүй зардал бий болох, төлбөр тооцооны маргаан үүсэх

3.6.3. Өгсөн зөвлөмж:

Ерөнхий нягтлан бодогчийн төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах үүргийн хэрэгжилтийг хангах

3.6.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлд ирүүлсэн тайлбарын үндэслэлийг хянаж, зөвлөмж өгөхөөр шийдвэрлэсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.Аудит хийсэн санхүүгийн тайлан

а. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	-	840,450.00
33	АВЛАГА	-	840,450.00
335	Бусад авлага	-	840,450.00
3351	Байгууллагаас авах авлага	-	840,450.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	-	840,450.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	2,799,200,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	2,799,200,000.00
413	Өглөг	-	2,799,200,000.00
4136	Бусад өглөг	-	2,799,200,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	2,799,200,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-	(2,798,359,550.00)
51	Засгийн газрын хувь оролцоо	-	(2,798,359,550.00)
512	Хуримтлагдсан үр дүн	-	(2,798,359,550.00)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(2,798,359,550.00)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	-	840,450.00

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,821,862,200.00	25,805,276,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	18,588,325,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	18,588,325,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	18,588,325,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	18,588,325,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,821,862,200.00	7,216,951,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	6,821,862,200.00	7,216,951,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	6,821,862,200.00	7,216,951,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	6,821,862,200.00	28,603,636,150.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,821,862,200.00	28,603,636,150.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,853,453,300.00	5,724,655,084.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,853,453,300.00	5,724,655,084.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,853,453,300.00	5,724,655,084.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	968,408,900.00	22,878,981,066.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	21,387,500,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	21,387,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	968,408,900.00	1,491,481,066.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	968,408,900.00	1,491,481,066.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-	(2,798,359,550.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-	(2,798,359,550.00)

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	6,821,862,200.00	25,805,276,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	18,588,325,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	18,588,325,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	18,588,325,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	18,588,325,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,821,862,200.00	7,216,951,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	6,821,862,200.00	7,216,951,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	6,821,862,200.00	7,216,951,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	6,821,862,200.00	25,805,276,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,821,862,200.00	25,805,276,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,853,453,300.00	5,725,495,534.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,853,453,300.00	5,725,495,534.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,853,453,300.00	5,725,495,534.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	968,408,900.00	20,079,781,066.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	18,588,300,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	18,588,300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	968,408,900.00	1,491,481,066.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	968,408,900.00	1,491,481,066.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	(2,143,551,730.00)	-	(2,143,551,730.00)
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	(2,143,551,730.00)	-	(2,143,551,730.00)
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	2,143,551,730.00	-	2,143,551,730.00
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(2,798,359,550.00)	-	(2,798,359,550.00)
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	(2,798,359,550.00)	-	(2,798,359,550.00)

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	49,024,334,200.00	24,313,795,534.00	(24,710,538,666.00)	49.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	49,024,334,200.00	24,313,795,534.00	(24,710,538,666.00)	49.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,020,334,200.00	5,725,495,534.00	(2,294,838,666.00)	71.39
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,020,334,200.00	5,725,495,534.00	(2,294,838,666.00)	71.39
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,020,334,200.00	5,725,495,534.00	(2,294,838,666.00)	71.39
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41,004,000,000.00	18,588,300,000.00	(22,415,700,000.00)	45.33
2132	Бусад урсгал шилжүүлэг	41,004,000,000.00	18,588,300,000.00	(22,415,700,000.00)	45.33
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	41,004,000,000.00	18,588,300,000.00	(22,415,700,000.00)	45.33
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	49,024,334,200.00	24,313,795,534.00	(24,710,538,666.00)	49.60
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	8,020,334,200.00	5,725,470,534.00	(2,294,863,666.00)	71.39
131001	Улсын төсвөөс санхүүжих	8,020,334,200.00	5,725,470,534.00	(2,294,863,666.00)	71.39
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	41,004,000,000.00	18,588,325,000.00	(22,415,675,000.00)	45.33
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	41,004,000,000.00	18,588,325,000.00	(22,415,675,000.00)	45.33
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	13,782	10,323	(3,459)	74.90
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	41	34	(7)	82.93
610002	Төсвөөс гадуур байгууллага	41	34	(7)	82.93
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	13,741	10,289	(3,452)	74.88
632	МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ	13,741	10,289	(3,452)	74.88
632002	Хувийн МСҮТ	13,741	10,289	(3,452)	74.88

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2019			САГ-2020/11/СТА-ЗГТС
Шалгагдсан байгууллагын нэр:	ХНХЯ-Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	
1	Тэтгэлгийн зардлын төлбөрийн баримтад харилцагч байгууллагын нэхэмжлэхийг хавсаргаагүй, цахим системд оруулсан /МСҮТ-ийн оруулсан/ суралцагчдын нэрсийн дагуу, хувийн дансруу шууд шилжүүлэн олгосон				
2	Тайлант онд 34170 суралцагчдад 41,004,000.0 мянган төгрөгийн тэтгэлэг олгохоор төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 15,490 гаран суралцагчдад 18,588,300.0 мянган төгрөгийн тэтгэлэг олгож, төсвийн гүйцэтгэл 45.3 хувиар биелэгдсэн				
3	Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативийг 2012 оноос хойш өөрчлөн батлуулаагүй				
4	Сургалтын төвд олгохоор тооцсон 5 дугаар сарын хувьсах зардлын санхүүжилтийг 27,342.6 мянган төгрөгөөр нэмж олгосон	27,342.6			
5	Тайлант онд яамны Дотоод хяналт, шалгалт үнэлгээний газраас 13-н сургалтын төвд суралцаж буй 4489 суралцагчдын тоонд шалгалт хийхэд 1403 хасагдаж, 3086 суралцагчаар баталгаажуулсан нь 84-н МСҮТ-д суралцаж буй хүүхдийн тоо цахим бүртгэлийн тооноос дутуу байх, санхүүжилт илүү олгогдох эрсдэлтэйг харуулж байна.				
6	Мэргэжлийн сургалтын төвүүдийн суралцагчдад олгосон тэтгэлгийн санхүүжилтийг жилийн эцэст тооцоо нийлж, үлдэгдлийг тулган баталгаажуулаагүй, цахим системд оруулсан мэдээлэлд үндэслэн санхүүгийн тайланд тусгасан байна.				
		27,342.6			

[illegible]